

## ХУРАЛДААНЫ ТОЙМ

### ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН 2016 ОНЫ ХОРИННАЙМДУГААР ХУРАЛДААН

Хуралдаан 2016 оны есдүгээр сарын 19-ны 15 цаг 15 минутад эхэлж, 15 цаг 41 минут хүртэл Төрийн албаны зөвлөлийн хуралдааны танхим (Засгийн газрын 11 дүгээр байрны 301 тоот өрөө)-д болж, нийт 36 минут үргэлжлэв.

№	Хэлэлцсэн асуудал	Гарсан шийдвэр
1	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан тушаалд томилогдох удирдах ажилтны сонгон шалгаруулалтын тайлан, уг албан тушаалд томилогдох ажилтанд дүгнэлт гаргах тухай	<p>Төрийн албаны тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.6, 35<sup>1</sup> дугаар зүйлийн 35<sup>1</sup>.1.4, Засгийн газрын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.8 дугаар зүйл, Яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1, Улсын Их Хурлын 2003 оны 13 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”-ын 32, 39 дүгээр зүйлүүдийг тус тус баримталж, Төрийн албаны зөвлөлийн 2016 оны 9 дүгээр сарын 15-ны өдрийн хуралдааны шийдвэр, дүгнэлтийг үндэслэн:</p> <p>Лхагвасүрэнгийн Баяртулгыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан тушаалд томилогдох төрийн жинхэнэ албаны удирдах ажилтны нөөцөд бүртгэж, уг албан тушаалд томилуулахаар нэр дэвшүүлж, Монгол Улсын Засгийн газарт санал болгох тухай Монгол Улсын төрийн албаны зөвлөлийн тогтоол гарахаар тогтов.</p>

### ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН АЖЛЫН АЛБА

